



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 385

Улаанбаатар хот

Г “Цагдуултай” ХК-ийн үнэт цаасны 7  
арилжааг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Хорооны 2008 оны 77 дугаар тогтоолын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Цагдуултай” ХК-ийн үнэт цаасны арилжааг 2012 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.

2. “Цагдуултай” ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэхийг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор “ҮЦТТТХТ” ХХК дахь данс нь нээгдээгүй байгаа хувьцаа эзэмшигчдийн дансыг компанийн санхүүжилтээр нээлгэхийг “Цагдуултай” ХК/Х.Хавалхат/-д үүрэг болгосугай.

4. “Цагдуултай” ХК-ийн хувьцаа эзэмшигч 10.09% буюу 5047 ширхэг хувьцаа эзэмшигч Х.Хавалхат, 19.18% буюу 9592 ширхэг хувьцаа эзэмшигч Х.Сураган, 9.10% буюу 4549 ширхэг хувьцаа эзэмшигч “Монсек” ХХК, 8.18% буюу 4088 ширхэг хувьцаа эзэмшигч А.Ганбаатар, 19.69% буюу 9844 ширхэг хувьцаа эзэмшигч Б.Алимаа, 12.33% буюу 6164 ширхэг хувьцаа эзэмшигч С.Басай, 11.20% буюу 5600 ширхэг хувьцаа эзэмшигч Л.Дорлиг, 4.63% буюу 2317 ширхэг хувьцаа эзэмшигч О.Намсрай нарын өмчилж буй “Цагдуултай” ХК-ийн нийт 94.4% буюу 47,201 ширхэг хувьцааг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн нэг жилийн хугацаатайгаар тусгаарлахыг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын 4 дэх заалтаар тусгаарлалт хийсэн нэр дурдагдсан найман хувьцаа эзэмшигчдийн хооронд үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх ажиллагааг хязгаарлахгүй болохыг тэмдэглэсүгэй.

6. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь Хороонд тогтмол ирүүлж хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэн ажиллахыг “Цагдуултай” ХК/Х.Хавалхат/-д даалгасугай.

7. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН